



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 32 (169)

Монгол Улсын Засгийн Газрын тогтоол:

- *Дээд боловсролын тагадлан итгэлжээлийн үндэсний зөвлөлийн статусын тухай*
- *Хөдөлмөрийн холсний доод хэлжээг шинэчлэн тогтоох тухай*
- *Шүүхийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2000 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2000 оны наймдугаар сарын 28

№32 (169)

Гарчиг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

341. Дээд боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн статусын тухай	Дугаар 104	599
342. Музейн менежментийг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай	Дугаар 105	600
343. Дүрэм батлах тухай	Дугаар 107	600
344. Хөдөлмөрийн хэлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 108	615
345. Засгийн газрын хүндэт өргөмжлөөр шагнах тухай	Дугаар 109	615
346. Тусгай хэрэгцээний газарт хамааруулах тухай	Дугаар 113	615
347. Хөтөлбөр батлах тухай	Дугаар 114	619
348. Шүүхийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 116	622

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 7 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 104

Улаанбаатар
хот

**Дээд боловсролын магадлан
итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн
статусын тухай**

Гэгээрлийн яамны саналыг үндэслэн
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Дээд боловсролын магадлан
итгэмжлэлийн үндэсний зөвлөлийг төрийн бус
байгууллагын хэлбэрээр ажиллуулах нь зүйтэй гэж
үзсүгэй.

2.Дүрмээ Төрийн бус байгууллагын тухай
хуулийн дагуу өөрчлен шинэчилж Хууль зүйн
яаманд бүртгүүлэхийг Дээд боловсролын магадлан
итгэмжлэлийн үндэсний зөвлөлд үүрэг болгосугай.

3.Дээд боловсролын магадлан
итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн үйл
ажиллагаанд 5 жил тутам унэлгээ, дүгнэлт өгч
ажиллахыг Гэгээрлийн сайд А.Баттерддаалгасугай.

Монгол Улсын Ерөнхий
сайд

Р.АМАРЖАРГАЛ

Эрүүл мэнд, нийгмийн
хамгааллын сайд бөгөөд
Гэгээрлийн сайдын үүрэг
гүйцэтгэгч

С.СОНИН



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 7 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 105

Улаанбаатар
хотМузейн менежментийг гэрээгээр
гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Үндэсний түүхийн музейн харьяа Улс
терийн хилс хэрэгт хэлмэгдэггийн дурсгалын
музейн менежментийг гэрээгээр гүйцэтгүүлэхийг
Гэгээрлийн сайд А.Баттерд зөвшөөрсүгэй.

2. Музейн менежментийг гэрээгээр
гүйцэтгүүлэх төндерийн болзол, журмыг
боловсруулан холбогдох гэрээ байгуулан,
гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг Гэгээрлийн

сайд А.Баттер, Төрийн өмчийн хорооны дарга
Д.Зоригт нарт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий
сайд

Р.АМАРЖАРГАЛ

Эрүүл мэнд, нийгмийн
хамгааллын сайд бөгөөд
Гэгээрлийн сайдын үүрэг
гүйцэтгэгч

С.СОНИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 7 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 107

Улаанбаатар
хот

Дүрэм батлах тухай

Хедэлмөрийн тухай хуулийн 95 дугаар
зүйлийн 10 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол
Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс
шалтгаалсан ёвчин, хурц хордлогыг судлан бүртгэх
дүрэм"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан
"Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх

талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын
1994 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 171 дүгээр
тогтоолын 6 дугаар хавсралтыг хүчингүй болсонд
тооцусгай.

Монгол Улсын Ерөнхий
сайд

Р.АМАРЖАРГАЛ

Эрүүл мэнд, нийгмийн
хамгааллын сайд

С.СОНИН

*Засгийн газрын 2000 оны 107 дугаар
тогтоолын хавсралт*

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН
ЁВЧИН, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэ дүрмийн зорилго нь өмчийн бүх
хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага
(цаашид "ажил олгогч" гэнэ)-д гарсан
үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс
шалтгаалсан ёвчин, хурц хордлого /цаашид
"үйлдвэрлэлийн осол" гэнэ/-ын шалтгааныг
судалж тогтоох, тэдгээрийг бүртгэх,
тайлагнах, мэдээлэхтэй холбогдсон үйл
ажиллагааг зохицуулахад оршино.

2. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс
шалтгаалсан ёвчин, хурц хордлогыг судалж

бүртгэх үйл ажиллагаанд Хедэлмөрийн тухай
хууль, энэ дүрэм болон холбогдох бусад
хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

3. Энэ дүрмийг Монгол улсын нутаг
дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ажил олгогч,
иргэд, хуульд өөрөөр заагаагүй бол гадаадын
болон хамтарсан хөрөнгө оруулалттай
хуулийн этгээдийн ажил олгогч нэгэн адил
мердөнө.

4. Үйлдвэрлэлийн осол, хурц
хордлогыг судлан бүртгэхтэй холбогдсон гарах
бүх зардал (бичиг хэрэг, тээвэр, судалгаа



шинжилгээний түүнчлэн шинжээчийн болон комиссын үйл ажиллагааны)-ыг үйлдвэрлэлийн осол бүртгэгдсэн тухайн ажил олгогч хариуцна.

5. Дараах нехцэл байдалд үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн нелөөлөлд өртсөнөөс гарсан ослыг үйлдвэрлэлийн осолд оруулж тооцно:

а/ажилтан ажлын үндсэн ба туслах байранд, эсхүл албан томилолтоор, мөн гэрээ, хэлэлцээрийн дагуу бусад газарт ажил үүргээ гүйцэтгэж байхдаа, тэрчлэн ажлын байр, нэгж, салбарын хооронд байнга явж ажлаа гүйцэтгэх ажлын цагаар бүх терлийн тээврийн хэрэгслэл, ердийн хасгаар буюу явган явж байгаад өртсөн осол;

б/ажлын байраа орхих боломжгүй ажил үүрэг гүйцэтгэх ажлын байрандаа амарч байх, ажил эхэлжийн өмнө болон ажил дууссаны дараа ажлын байр, багаж хэрэгслээ эмхлэн цэгцлэх, ажлын хувцсаа солих, усанд орох, ажил хүлээнцэх үед гарсан осол;

в/ажилдаа ирэх, буцах замдаа аливаа тээврийн хэрэгслээр буюу явган явж байхдаа өртсөн осол (энэхүү ослыг тогтоохдоо тухайн ажилтын гэр, ажлын байр хоорондын чиглэл, цаг хугацааг үндэс болгоно);

г/үндсэн ажлаа гүйцэтгэх үедээз байгаль, цаг уур, гол, усны гэнэтийн аюул, цацраг идэвхит болон химиийн хорт бодисын нелөөлөл, түүнчлэн хорхой шавьж, мал, амьтны халдлагад өртсөнөөс үүссэн осол;

д/гоц халдварт өвчний голомтод ажиллаж байхдаа өртсөн осол.

6. Хөдөлмөрийн тааламжгүй нехцэл, түүхий эд, материалын бохирдолтоос шалтгаалсан хурц хордлогыг мэргэжлийн хяналтын холбогдох байгууллагын дүгнэлтийг үндэслэн үйлдвэрлэлийн осолд тооцож болно.

7. Дараах нехцэл байдалд гарсан

ослыг үйлдвэрлэлийн осолд оруулж тооцожгүй:

а/ажил олгогчийн шийдвэрлэгээр үндсэн үүрэгт ажлаасаа өөр ажил гүйцэтгэж байгаад осолдох;

б/ажлын байрандаа согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэнээс осолдох;

в/ажлын байраа орхиж явсан, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан боловч хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимыг ноцтой зөрчсөнөөс осолдох;

г/гэмт хэрэг үйлдэх үедээ өөрийн биед гэмтэл учруулах.

8. Иргэд хоорондын гэрээгээр ажил гүйцэтгэх үед гарч болзошгүй үйлдвэрлэлийн ослын үед авах арга хэмжээний талаар Талууд гэрээнд тодорхой тусгасан байх шаардлагатай.

Үйлдвэрлэлийн осол гарсан тохиолдолд энэ дүрмийн дагуу гэрээнд оролцогчид түүнийг судлан бүртгэж, хохирлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

9. Батлан хамгаалах болон цагдаагийн байгууллагад гарсан үйлдвэрлэлийн ослыг энэ дүрмийн дагуу судалж бүртгэнэ.

10. Үйлдвэрлэлийн ослын талаар эмнэлгийн задлан шинжилгээ хийлгүүлэх, мэргэжлийн байгууллагаар судалгаа, дүгнэлт гаргуулахаар хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчаас тавьсан шаардлагыг холбогдох байгууллага түргэн шуурхай барагдуулах үүрэгтэй.

Хоёр. Үйлдвэрлэлийн ослыг судлан тогтоох орон тооны бус байнгын комиссын ажиллах журам

11. Ажил олгогчоос үйлдвэрлэлийн ослыг судлан тогтоох орон тооны бус байнгын комиссыг ажил олгогч ба ажилтны



төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд комиссын дарыг томилсон байна.

Томилолт, гэрээ, хэлэлцээрийн дагуу өөр байгууллагад ирж ажилт үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан болон үйлдвэрлэлийн дадлагаа хийж буй оюутан, сурагч үйлдвэрлэлийн осолд өртсөн тохиолдолд осолдогчийн харьяалах байгууллагын төлөөлөгчийг комиссын бүрэлдэхүүнд оролцуулан тухайн ослын байдлыг судлан тогтоож уг үйлдвэрлэлийн ослыг гэм буруутай ажил олгогчид хамааруулан бүртгэнэ.

Үйлдвэрлэлийн ослын онцлог, бий болсон нехцелөөс хамааруулан комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж болно.

12. Комисс нь осолдогч нийгмийн даатгалын шимтгэл төлөн зэсхийг үл харгалзан энэ дурмийн хавсралт маягтын дагуу /YOTA-1/ үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэж акт тогтооно.

13. Комисс нь үйлдвэрлэлийн осоп гарсан тухай мэдээ хүлээн авмагц 24 цагийн дотор ослын байдалтай газар дээр нь танилцаж шалтгааныг судлан тогтооно. Зайлшгүй шаардлагаар иж бүрэн шинжилгээ, судалгаа хийхээр бол үйлдвэрлэлийн ослыг судлан тогтоох ажлыг 1 сарын хугацаанд гүйцэтгэж болно.

Шаардлагатай тохиолдолд комисс нь терөлжсөн улсын хяналтын байгууллагын байцаагчийн дүгнэлт гаргувуна.

14. Үйлдвэрлэлийн ослын актад ослын шалтгааныг судалж тогтооход оролцсон комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

Актыг хөдөлмөрийн хяналтын болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч хянан батална.

Хүрц хордлоготой холбогдсон ослын актаг хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч хянаж батална.

15. Энэ дүрмийн 7-д дурдсан ослыг судлан

тогтоосон актын баруун доод буланд "осолдогчийн буруугаас болсон" гэсэн тэмдэглэл хийж, ажил олгогч гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

16. Үйлдвэрлэлийн ослыг судалж тогтоосон акт, дүгнэлтийг 4 хувь үйлдэж, осолдогч буюу гэр бүлийн хүмүүс, нийгмийн даатгалын хэлтэс, орон нутгийн хөдөлмөрийн буюу хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид хувийг ёгч, улдзх хувийт тухайн ажил олгогч архивын нэгж болгож хадгална.

17. Ажил олгогч нь үйлдвэрлэлийн ослыг судалж дууссанаас хойш 3 хоногийн дотор ослын актын хувийт тухайн осолдогч буюу гэр бүлийн хүмүүст өгөх үүрэгтэй.

18. Ноцтой, хор аюул, хохирол ихтэй үйлдвэрлэлийн осол гарсан тохиолдолд тухайн ослын акт тогтоох ажлыг Засгийн газраас томилсон комисс гүйцэтгэнэ.

Гурав. Орон тооны бус байнгын комиссын үүрэг, эрх

19. Комисс нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/ үйлдвэрлэлийн ослын талаархи гомдол, санал, хүснэгтийг хүлээн авч магадлан шалгаж шийдвэрлэх;

б/ үйлдвэрлэлийн осолд хүргэсэн шалтгааныг арилгах арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

в/ үйлдвэрлэлийн ослын шалтгааныг судлан тогтоосон акт, дүгнэлтийг үндэслэн нийт ажилтны дунд сурталчилгааны болон сэргэжлиүүлэх ажлыг зохион байгуулж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ажил олгогчид зөвлөмж өгөх;

г/ үйлдвэрлэлийн ослын тухай мэдээг осол гарсан тухайн үед нь мэдээлэх;

д/ үйлдвэрлэлийн ослын актаг осолд өртсөн хүн бүрээр тогтоох.

20. Комисс нь дор дурдсан эрх здэлнэ:



а/үйлдвэрлэл, ажлын байранд нэвтрэн орж, үйлдвэрлэлийн осол гарсан нехцел байдалтай биечлэн танилцах;

б/үйлдвэрлэлийн ослын шинж байдлаас хамаарч мэргэжилтэн шинжээч оролцуулах, ослыг бүртгэх ажилд зөвлөгөө, тусламж авах, ослын талаар техникийн тооцоо, лабораторийн шинжилгээ, туршилт хийлгүүлэх, дүгнэлт гаргуулах;

в/осолдогч болон осол гарах үед байсан гэрчийн этгээд, мэргэжлийн хүмүүс, удирдах ажилтнуудаас үйлдвэрлэлийн ослын талаар мэдээлэл авах, санал дүгнэлт гаргуулах;

г/үйлдвэрлэлийн ослыг судлах явцад зайлшгүй шаардлагатай тохиолдолд ажил олгогчоос ажиллах байр, техник хэрэгсэл, унаагаар хангуулах.

Дөрөв.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхэд бүрдүүлэх бичиг баримт

21.Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэхэд дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

а/осолдогч тус бүрийн үйлдвэрлэлийн ослын тухай акт;

б/үйлдвэрлэлийн осол гарсан ажлын байр, талбайн фото ба гар зураг, схем;

в/үйлдвэрлэлийн осолтой холбоотой асуудлаар холбогдох хүмүүсээс авсан мэдээлэл, ярилцлага;

г/үйлдвэрлэлийн ослын шалгааны талаархи эмнэлгийн болон мэргэжилтэн, шинжээчийн дүгнэлт, лабораторийн шинжилгээ, туршилтын дүн;

д/үйлдвэрлэлийн осолд өртсөн ажилтны сургалтад хамрагдсан тухай гэрчлэх баримт болон осолдогчийн гарын үсэг бүхий зааварчилгааны хуулбар;

е/ажлын хувцас, хамгаалах

хэрэгслийн олголт, тэдгээрийн эдэлгээний хугацааны тухай баримт;

ж/хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа хариуцсан албан тушаалтны болон үйлдвэрлэлийн осолд өртсөн ажилтны эрх, үүргийг тодорхойлсон дурэм, заавар, тушаал, хууль эрхийн бусад актаас хэсэгчлэн авсан хуулбар;

з/үйлдвэрлэлийн ослын тухай яаралтай мэдээлэх хуудас;

и/хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт (тусдаа дүгнэлт гаргасан тохиолдолд);

к/цогцост хийсэн задлан шинжилгээний дүгнэлт.

Тав.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан ёвчин, хурц хордлоготой холбогдсон тэтгэвэр, тэтгэмж, нэхэн төлбөрийг тогтоох журам

22.Тухайн осолтой холбогдуулан нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, нэхэн олговрыг тогтоох асуудлыг үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэсэн баримт бичиг, хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн баталгаажуулсан акт, дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэл, дүүрэг/сум/-ийн Засаг даргын томилсон байнгын комисс /орон тооны бус/ шийдвэрлэнэ.

23.Уг байнгын комисс нь холбогдох материалыг хулээн авснаас хойш 14 хоногийн дотор асуудлыг шийдвэрлэнэ.

Зургаа.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан ёвчин, хурц хордлогыг мэдээлэх, тайлан гаргах

24.Үйлдвэрлэлийн ослын тухай осолдогч вөрөө буюу осол гарсныг анх үзэж мэдсэн этгээд ажил олгогчид яаралтай мэдээлэх арга хэмжээ авна.



25.Үйлдвэрлэлийн осол гарсан тухай мэдээ авмагц ажил олгогч нь дор дурдсан байгууллага, албан тушаалтанд яаралтай мэдээлэх үүрэгтэй (хавсралт 2):

а/эмнэлгийн байгууллага;

б/тухайн орон нутгийн мэргэжлийн хяналтын алба;

в/ажил олгогчийн харьялах дээд байгууллага;

г/орон нутгийн цагдаагийн байгууллага;

д/шаардлагатай тохиолдолд төрөлжсен хяналтын алба, иргэний хамгааллын байгууллага.

26.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн ослын улмаас учирсан хохирлыг арилгах арга хэмжээг шуурхай зохион байгуулна. Ингэхдээ эрх бүхий комисс ирж судалгаа шинжилгээ хийх хүртэл үйлдвэрлэлийн осол гарсан объектын тухайн үеийн байдлыг вөрчилж болохгүй.

27.Ажлын байр, үйлдвэрлэлийн ослын объектыг тухайн үеийн байдлаар байгалах нь иргэдийн амь нас, зруул мэндийг хамгаалах, ослын уршгийг арилгахад саад учруулах, улсын аюулгүй байдалтай холбоо бүхий үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг зогсооход хүргэж болзошгүй нөхцөлд ажил олгогч холбогдох арга хэмжээг авч, үйлдвэрлэлийн ослын тухай тэмдэглэл, фото болон гар зураг, схемийг бүрдүүлсэн байх үүрэгтэй.

28.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол гарсан тухай бүр мэдээ гаргаж, орон нутгийн хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид хүргүүлнэ (хавсралт 5).

29.Ажил олгогчоос ирүүлсэн мэдээг үндэслэн орон нутгийн хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нь үйлдвэрлэлийн ослын тухай

тайланг хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргаж хөдөлмөрийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ (хавсралт 3, 4).

30.Мэргэжлээс шалтгаалсан өвчний холбогдох мэргэжлийн байгууллага (Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс)-ын шийдвэрийг үндэслэн бүртгэнэ.

31.Мэргэжлээс шалтгаалсан өвчний тайлан мэдээ гаргах, дүгнэх ажлыг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрмээр зохицуулна.

32.Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс нь мэргэжлээс шалтгаалсан өвчний тайлан хөдөлмөрийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон холбогдох бусад байгууллагад хүргүүлнэ.

Долоо.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлоготой холбогдсон маргааны шийдвэрлэх

33.Үйлдвэрлэлийн ослын талаар гаргасан комиссын актyg зөвшөөрөхгүй тохиолдолд ажил олгогч болон ажилтан нь гомдлоо хөдөлмөрийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргана.

34.Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нь байгууллагын комиссын гаргасан акттай санал нийлзэгүй тохиолдолд мэргэжлийн болон холбогдох дээд байгууллагад санал тавьж, судалгаа шинжилгээ хийлгүүлж, дүгнэлт гаргуулж болно.

35.Үйлдвэрлэлийн осол гарснаас хойш 6 сарын хугацаа өнгөрсөн бол үйлдвэрлэлийн ослын актyg нехэн тогтоохгүй.

36.Үйлдвэрлэл гарсан ослыг нуун дарагдуулсан, буруутай үйл ажиллагаа нь үйлдвэрлэлийн осол гарахад нөлөөлсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хулээлгэнэ.



**БАТЛАВ.Хөдөлмөрийн (хөдөлмөрийн эрүүл ахуйн)
хяналтын улсын байцаагч (тэмдэг дарна)
/гарын үсэг/ _____ (нэр)**

**ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛЫГ ТОГТООСОН
АКТ (YOTA)**

... оны ... сарын ...-ны өдөр үйлдэв.

1.Аж ахуйн нэгж, байгууллагын нэр _____
2.Байгууллагын хаяг (аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, гудамжны нэр) _____

3.Өмчийн хэлбэр _____

4.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн хүний овог _____ нэр
_____ Төрсөн ____ он ____ сар ____ өдөр, нас ___, хүйс ____

Иргэний үнэмлэхийн дугаар _____

Нийгмийн даатгалын дэвтрин дугаар _____

Албан тушаал _____

Боловсрол _____ мэргэжил

Ажилд орсон ____ он ____ сар ____ өдөр, тушаал, шийдвэрийн № ____

Ажилласан нийт хугацаа ___, үүнээс тус байгууллагад ____, шимтгэл төлж ажилласан хугацаа _____

Байгууллагын захиргаанаас аюулгүй ажиллагааны урьдчилсан зааварчилгаа авсан байдал:

Эрүүл мэндийн үзлэгт сүүлчийн удаа орсон ____ он ____ сар ____ өдөр
Оршин суудаг нутаг дэвсгэр, гэрийн хаяг _____

5.Үйлдвэрлэлийн осол,хурц хордлого гарсан ____ он ____ сар ____ өдөр_цаг_ мин

6.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан цех, тасаг, хэсэг, ажлын байрны нэр

8.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын хэлбэр (зур) яс хугарах, үе мултрах, зөвлөн зд гэмтэж бяцарсан, тасарсан, зүсэгдсэн, гадаад, дотоод гэмтэл, биологи, химийн бодисын үйлчлэл

9.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гаргахад хүргэсэн шалтгаан, хүчин зүйл



10.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас ажилтны эрүүл мэндэд учирсан хохирол

11.Комиссын дүгнэлт: Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гаражад шууд нелөөлсөн хүчин зүйл, буруутай этгээдийн үйл ажиллагааны тухай тодорхой заана

Комиссын шийдвэр



АКТ ТОГТООСОН КОМИССЫН

ДАРГА _____ / _____
 ГИШҮҮД _____ / _____
 _____ / _____
 _____ / _____
 _____ / _____
 _____ / _____

Тайлбар: Байгууллагын тогтоосон акттай санал нийлэхгүй тохиолдолд хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч тусдаа дүгнэлт гаргана.

Хавсралт 2

**ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫН ТУХАЙ
ЯАРАЛТАЙ МЭДЭЭЛЭХ ХУУДАС**

1. Аж ахуйн нэгж, байгууллагын нэр _____
2. Цех, тасгийн нэр _____
3. Осол, хурц хордлогын хэлбэр: хөнгөн, дунд, хүнд, бүлэг, хүн нас барсан (зурах)
4. Осол, хурц хордлогод ертсэн хүний тоо _____
5. Осол, хурц хордлого гарсан ____ он ____ сар ____ өдөр ____ цаг ____ минут
6. Мэдээлэл өгсөн ____ он ____ сар ____ өдөр ____ цаг ____ минут
7. Осол, хурц хордлогын тухай мэдээлэл: _____

Энэхүү мэдээллийг _____

нарт өгсөн болно.

Тайлбар: Мэдээг бичгээр, утсаар өгч болно. Мэдээг утсаар өгсөн бол хаана, хэнд мэдээлсэн тухайгаа энэ хуудсанд тэмдэглэж осол, хурц хордлогын материалд хавсаргана.

Мэдээ өгсөн хүний албан тушаал _____

_____ / _____ / _____

(гарын үсэг)

(нэр)

Мэдээ авсан хүний албан тушаал _____

_____ / _____ / _____

(гарын үсэг)

(нэр)



Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн зүүл
ахуйн хяналтын улсын байцаагчид нь
ҮІ, ХП сарын 15-ны дотор Хөдөлмөрийн
хяналтын улсын албанц ирүүлнэ.

(АЙМАГ, ХОТ, ДУУРЭГ,
ТУСГАЙ ГАЗРЫН НЭР) ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛЫН ____ ОНЫ
ДУГААР ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

(вссын дунгэр)

Салбар Үзүүлэлт	Мөрийн №	Эрчим хүч	Уул уурхай	Хөдөө аж ахуй	Барилга	Хянган-хүнс	Зам, тэзвэр, холбоо	Худалдаа, үйлчилгээ	Боловсрол	Эрүүл мэнд	Бусад	Нийт дун
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Ажилтны дундаж тоо	01											
Үүнээс: эмэгтэй	02											
Ослын тоо	03											
Үүнээс: булаг ослын тоо	04											
Осолд орсон хүний тоо	05											
Үүнээс: эмэгтэй	06											
Нас барсан хүний тоо	07											
Тахир дутуу болсон хүний тоо	08											
Хөдөлмөрийн чадвар түр алдсан хүний тоо	09											
Мэргэжлийн ажлаас өөр ажилд шилжсан хүний тоо	10											
Ослын хэлбэр:												
Хүний амь үрэгдсэн	11											
Хүнд	12											
Хөнгөн	13											
Осолд оруулсан хүчин зүйл:												
Машин механизм, тоног төхөөрөмж	14											
Тээврийн хэрэгсэл:	15											
Өргөх төхөөрөмж	16											
Цахилгаан гүйдэлд цохиулсан	17											
Халаалт, түлэгдэлт, хөлдөлт	18											
Уналт, нуралт	19											
Адгуус амьтан	20											
Бусад	21											
Ослын шалтгаан:												
Машин механизм, тоног төхөөрөмжийн гэмтэл	22											
Тоног төхөөрөмжийн хийцийн алдаа	23											
Технологийн процесс зөрчсөн	24											



1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Аюулгүй ажиллах арга барилд хангалтгүй сургасан	25											
Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэлгүй ажилласан	26											
Онцгой ур чадвар шаардсан ажилд мэргэжлийн хүнийг ажиллуулаагүй	27											
Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл	28											
Бусад	29											
Осолдогчийн насны ялгаа:												
18 хүртэл	30											
18-35 хүртэл	31											
35-аас дээш	32											
Ажилласан хугтацаа:												
5 хүртэл жил	33											
5-15 хүртэл жил	34											
15-аас дээш жил	35											
Аж ахуйн нэгж, байгууллагын ёмчийн хэлбэр:												
Улсын үйлдвэрийн газар, териин болон териийн ёмч давамгайлсан	36											
Хувийн	37											
Төсвийн	38											
Гадаадын ба хамтарсан хөрөнгө оруулалттай	39											

Тайллан доорхи маягаар гаргаж баланслуулсан байна. Мөрийн дугаар 01, 02-ын дагуу бичигдэх ажилтны жилийн дундаж тоог орон нутгийн статистикийн албанаас гаргуулан авна. Бүлэг осолд 2-оос дээш хүн хамрагдсан ослыг тооцно.

Мөрийн дугаар 05-тай мөрийн дугаар 07, 08, 09-ийн нийлбэр, мөрийн дугаар 11, 12, 13-ын нийлбэр, мөрийн дугаар 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21-ийн нийлбэр, мөрийн дугаар 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29-ийн нийлбэр, мөрийн дугаар 30, 31, 32-ын нийлбэр, мөрийн дугаар 33, 34, 35-ын нийлбэр тус тус тэнцүү байна. Мөрийн дугаар 03-тай мөрийн дугаар 36, 37, 38, 39-ийн нийлбэр тус тус тэнцүү байна.

Тайлан мэдээ гаргасан:

Хөдөлмөрийн хяналтын

улсын байцаагч _____ / _____ /
(тэмдэг) (гарын үсэг) (нэр)

_____ он _____ сар _____ өдөр



Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл
ахуйн хяналтын улсын байцаагчид нь
ҮІ, ХП сарын 15-ны дотор Хөдөлмөрийн
хяналтын улсын албанц ируулнэ.

(АЙМАГ, ХОТ, ДҮҮРЭГ,
ТУСГАЙ ГАЗРЫН НЭР) ХУРЦ ХОРДЛОГЫН ОНЫ
ДУГААР ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

(өссөн дүнгээр)

Салбар	Мэрийн №	Эрчим хүч	Ул Уурхай	Хөдөө аж ахуй	Барилга	Хөнгөн, хүнс	Зам, тээвэр, холбоо	Худалдаа, үйлчилгээ	Боловсрол	Эрүүл мэнд	Бусад	Нийт дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Ажилтны дундаж тоо	01											
Үүнээс: эмэгтэй	02											
Хурц хордлого гарсан тоо	03											
Үүнээс: бүлэг хурц хордлого	04											
Хурц хордлогод өртсөн хүний тоо	05											
Үүнээс: эмэгтэй	06											
Нас барсан хүний тоо	07											
Тахир дутуу болсон хүний тоо	08											
Хөдөлмөрийн чадвар түр алдсан хүний тоо	09											
Мэргэжлийн ажлаас өөр ажилд шилжсэн хүний тоо	10											
Хурц хордлогын хэлбэр:												
-хөнгөн	11											
-дунд	12											
-хунд	13											
Хүний амь үрэгдсэн	14											



1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Хүрц хордлогын хүчин зүйл:												
Угаарын хий	15											
Органик уусгагч	16											
Пестицид	17											
Нефтийн бүтээгдэхүүн	18											
Аммиак	19											
Хүчил шүлт	20											
Хүнд металлын нэгдэл	21											
Цацраг бодис	22											
Бусад химийн бодис	23											
Хүрц хордлогын шалтгаан:												
Машин механизм, тоног төхөөрөмжийн гэмтэл	24											
Тоног төхөөрөмжийн битүүмжлэл алдагдсан	25											
Технологийн процесс зөрчсөн	26											
Аюулгүй ажиллах арга барилд хангалтгүй сургасан	27											
Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэлгүй ажилласан	28											
Онцгой ур чадвар шаардсан ажилд мэргэжлийн хүнийг ажиллуулаагүй	29											
Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл	30											
Бусад	31											
Насны ялгаа:												
18 хүртэл	32											
18-35 хүртэл	33											



35-аас дээш	34										
Ажилласан хугацаа:											
5 хүртэл жил	35										
5-15 хүртэл жил	36										
15-аас дээш жил	37										
Аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн хэлбэр:											
Улсын үйлдвэрийн газар, төрийн болон терийн өмч давамгайлсан	38										
Хувийн	39										
Төсвийн	40										
Гадаадын ба хамтарсан хөрөнгө оруулалттай	41										

Тайлбар: Хурц хордлогод үйлдвэрлэл, аж ахуйн нэгж, байгууллагад химиин бодисын хэрэглээтэй холбогдож гарсан хордлогыг авах ба энд ахуйн хордлого хамаарахгүй.

Тайланг доорхи маягаар гаргаж баланслуулсан байна. Мөрийн дугаар 01, 02-ын дагуу бичигдэх ажилтны жилийн дундаж тоог орон нутгийн статистикийн албанаас гаргаж авна.

Мөрийн дугаар 05-тай мөрийн дугаар 07, 08, 09-ийн нийлбэр, мөрийн дугаар 11, 12, 13, 14-ийн нийлбэр, мөрийн дугаар 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23-ын нийлбэр, мөрийн дугаар 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31-ийн нийлбэр, мөрийн дугаар 32, 33, 34-ийн нийлбэр, мөрийн дугаар 35, 36, 37-гийн нийлбэр тус тус тэнцүү байна. Мөрийн дугаар 03-тай мөрийн дугаар 38, 39, 40, 41-ийн нийлбэр тус тус тэнцүү байна.

Тайлан мэдээ гаргасан:

Хөдөлмөрийн хяналтын
улсын байцаагч _____ / _____ /
(тэмдэг) (гарын үсэг) (нэр)

_____ он _____ сар _____ өдөр



**ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАХ
АНХАН ШАТНЫ БҮРТГЭЛИЙН МАЯГТ**

Байгууллагын нэр _____ салбар _____

Өмчийн хэлбэр _____

Хаяг _____

Нийт ажилтны тоо _____ үүнээс эмэгтэй _____

Осолдогчийн тухай мэдээлэл

Овог, нэр _____ нас _____, хүйс _____
Ажилласан нийт жил_____. үүнээс тус байгууллагад _____ мэргэжил
эрхэлж буй албан тушаалт _____ утасны №_____

Осолд өртсөн _____ он _____ сар _____ өдөр _____ цаг _____ минут

Гэрийн хаяг _____ Утас: _____

Хэлбэр		
Үйлдвэрлэлийн осол	Хурц хордлого	Зэрэг
<input type="checkbox"/> Дотор	<input type="checkbox"/> Дотор	<input type="checkbox"/> Нас барсан
<input type="checkbox"/> Гадар	<input type="checkbox"/> Гадар	<input type="checkbox"/> Хүнд
<input type="checkbox"/> Яс хугарсан	<input type="checkbox"/> Хоол боловсруулах	<input type="checkbox"/> Дунд
<input type="checkbox"/> Зеөлөн эд гэмтсэн	<input type="checkbox"/> эрхтэний замаар	<input type="checkbox"/> Хөнгөн
<input type="checkbox"/> Түлэгдэл	<input type="checkbox"/> Амьсгалгаар	<input type="checkbox"/> Булзг
<input type="checkbox"/> Бяцарсан	<input type="checkbox"/> Арьсаар	<input type="checkbox"/> Хеделмэрийн чадвар түр алдсан
<input type="checkbox"/> Тасарсан	<input type="checkbox"/> Хэсгийн	<input type="checkbox"/> Тахир дутуу болсон
	<input type="checkbox"/> Ерэнхий	<input type="checkbox"/> Мэргэжлийн өөр ажилд шилжсэн

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын	
Шалтгаан	Хүчин зүйл
<input type="checkbox"/> Машин механизм, тоног төхөөрөмжийн гэмтлээс	<input type="checkbox"/> Угаарын хий
<input type="checkbox"/> Тоног төхөөрөмжийн битүүмжлэл алдагдсаннаас	<input type="checkbox"/> Органик уусгагч
<input type="checkbox"/> Технологи процесс зерчсөнөөс	<input type="checkbox"/> Пестицид
<input type="checkbox"/> Аюулгүй ажиллагааны арга барилд хангалтгүй сургаснаас	<input type="checkbox"/> Нефть бүтээгдэхүүн
<input type="checkbox"/> Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэлгүй ажилласнаас	<input type="checkbox"/> Аммиак
<input type="checkbox"/> Онцгой ур чадвар шаардсан ажилд мэргэжлийн хүн ажиллуулаагүйгээс	<input type="checkbox"/> Хүчил шулт
<input type="checkbox"/> Хеделмэрийн хэвийн бус нөхцөлөөс	<input type="checkbox"/> Хүнд металлын нэгдэл
<input type="checkbox"/> Тоног төхөөрөмжийн хийцийн алдаанаас	<input type="checkbox"/> Цацраг идэвхт бодис
	<input type="checkbox"/> Бусад химийн бодис
	<input type="checkbox"/> Машин механизм, тоног төхөөрөмж
	<input type="checkbox"/> Тээврийн хэрэгсэл
	<input type="checkbox"/> Өргөх төхөөрөмж
	<input type="checkbox"/> Цахилгаан гүйдэлд цохиулсан
	<input type="checkbox"/> Халалт, хөлдөлт, түлэгдэлт
	<input type="checkbox"/> Уналт, нуралт
	<input type="checkbox"/> Адгуус амьтан
	<input type="checkbox"/> Бусад

Анхан шатны тусламж



Анхны шатны тусламж үзүүлсэн хүний нэр _____
 Эмнэлгэг _____ Эмчийн нэр _____
 Үзүүлсэн тусламж _____

Тусламж үзүүлсэн он сар өдөр цаг минут

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого дахин гарах магадлал		
<input type="checkbox"/> - Бага	<input type="checkbox"/> -Болзошгүй	<input type="checkbox"/> -Байхгүй

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын хэлбэр, шалтгаан, хүчин зүйл, осол, хурц хордлого дахин гарах магадлал гэсэн асуултуудын аль тохиорох хэсэгт Тэмдэглэгээ хийнэ.

Осол, хордлого дахин гарахаас урьдчилан сэргийлж		
Авсан арга хэмжээ	Хэзээ	Хэн

Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тухай бүр хавсралтын дагуу мэдээ гаргаж, орон нутгийн хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид 7 хоногийн дотор хүргүүлнэ.

Мэдээ өгсөн хүний _____
 (албан тушаал)

Гарын үсэг _____ / _____ /
 Нэр

_____ он _____ сар _____ өдөр



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 7 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 108

Улаанбаатар
хотХөдөлмөрийн хэлсний доод
хэмжээг шинчлэн тогтоох тухай

Хөдөлмөрийн хэлсний доод хэмжээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн үндэслэл Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Тер. аж ахуйн нэгж, байгууллагын ажилтн болон иргэд хоорондын хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын цагийн хөдөлмөрийн хэлсний доод хэмжээг 2000 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 146 төгрөг 45 монгоор шинчлэн тогтоосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан

"Хөдөлмөрийн хэлсний доод хэмжээг шинчлэн батлах тухай" Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 259 дутгаар тогтооплын 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Еренхий
сайд

Р.АМАРЖАРГАЛ

Зруул мэнд, нийгмийн
хамгааллын сайд

С.СОНИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 7 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 109

Улаанбаатар
хотЗасгийн газрын Хүндэт
өргөмжлөөр шагнах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн, төрийн байгууллагын өөрчлөлт, шинчлэл, Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх үйл хэрэгт үзүүлэх хувь нэмэр оруулаан идэвх зүтгэлтэй, бүтээлтэй ажиллаж байгааг нь тэмдэглэж дор дурдсан хүмүүсийг Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөөр шагнасугай:

- Гэгээрлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Рэгсүрэнгийн БАТ-ЭРДЭНЭ;
- Засгийн газрын алхах референт Гарьдан ДАГВА;
- Өмнөговь аймгийн Засаг дарга Банзрагчийн ЦЭДЭНСАМБА;
- Улсын ерөнхий прокурорын орлогч Цэнд-аюушийн ЖАМЬЯНСЭНГЭЭ;
- Монросцветмет нэгдлийн харьяа Хангайн уулсын үйлдвэрийн дарга

- Монгол Улсын Еренхий сайдын зөвлөх Сүрэнгийн БАДРАЛ;
- Авто замын газрын төслийн удирдагч Ламжавын ГОМБО;
- Улсын нийгмийн давтгалын ерөнхий газрын дарга Цэндийн СҮХБААТАР;
- Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга Лувсандоржийн ДАШДОРЖ;
- Шинжлэх ухааны академийн Палеонтологийн төвийн захирал, академич Ринченгийн БАРСБОЛД;
- Байгаль орчны яамны газрын орлогч дарга Ламжавын ДОРЖЦЭДЭН;

- Монгол Улсын Еренхий сайд Р.АМАРЖАРГАЛ
- Хууль зүйн сайд Д.ГАНБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 7 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 113

Улаанбаатар
хотТусгай хэрэгцээний газарт
хамааруулах тухай

Газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Шүүхийн шийдвэр билэлүүлэх байгууллагын тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Төвлөрсөн болон аймаг, нийслэлийн харьяалалтай хорих ангийн хамгаалалт, үйлдвэрлэлийн бусийг тусгай хэрэгцээний газарт

хамааруулж 1 дүгээр хавсралт ёсоор, төвлөрсөн хорих ангийн байршил, үйлдвэрлэлийн чиглэлийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

- Монгол Улсын Еренхий сайд Р.АМАРЖАРГАЛ
- Хууль зүйн сайд Д.ГАНБОЛД
- Байгаль орчны сайд С.МЭНДСАЙХАН



Засгийн газрын 2000 оны 113 дугаар
тогтоолын 1 дутээр хавсралт

ХОРИХ АНГИУДЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ЭДЭЛБЭР ГАЗАР

№	Хорихийн нэр	Байршил	Солбицр		Зүржийн нарагбор	Тусгай хэрэгцэний газарт хамаарах одро зэмсэгжж байгаа болон ашиглаж байгаа эрлийр газрууд /га-гаар/ амьдралын болон үйлдвэрийн бус	
			4	5		7	8
ТӨВЛӨРӨСН ХОРИХ АНГИ							
1	Аадрантын хорих ани	Төв аймийн Лүн сум	47°40'00"	105°28'00"			
			47°40'00"	105°29'30"			
			47°38'50"	105°29'30"			
			47°37'00"	105°27'00"			
			47°37'00"	105°26'15"			
			47°38'00"	105°26'15"	L-148-19	1160	10
			47°39'10"	105°27'00"			
			47°39'10"	105°27'00"			
			47°39'10"	105°28'00"			
2	Мянгылын хорих ани	Төв аймийн Баян сум	47°14'30"	107°35'40"			
			47°14'30"	107°38'00"	L-48-36		
			47°12'40"	107°38'00"			
			47°12'40"	107°35'40"	L-48-24	4940	20
			47°18'30"	107°31'30"			
			47°18'30"	107°32'20"	L-48-35		
			47°17'30"	107°32'20"			
			47°17'30"	107°31'30"			
			47°16'00"	107°50'00"			
			47°16'00"	107°54'00"			
			47°12'00"	107°54'00"			
			47°12'00"	107°50'00"			
			47°21'00"	107°30'00"			
			47°21'16"	107°30'00"			
			47°21'16"	107°30'23"			
			47°21'00"	107°30'23"			
3	Барилын материалын үйлдвэрлэлийн ашиглалтын оюнек захиргаа	Улаанбаатар	47°45'00"	107°17'40"			
		Ганц худаг	47°45'20"	107°17'40"			
		Тоосгын шавьрын орд	47°45'20"	107°19'00"			
			47°45'00"	107°19'00"	L-48-11	440	5
		Налайх	47°57'48"	106°57'31"			
		дүүргэ	47°58'04"	106°57'31"			
		Нүүрний	47°58'04"	106°57'55"			



		урхай	47°57'48"	106°57'55"			
4	Багануурин хорих айни	Төв аймгийн Мянганомырт сум	47°39'41"	108°16'11"			
			47°39'41"	108°16'42"			
			47°39'20"	108°16'42"	L-49-13	430	10
			47°39'20"	108°16'11"			
			47°40'30"	108°21'30"	L-49-1		
			47°40'55"	108°23'30"			
			47°40'10"	108°23'30"			
			47°39'50"	108°21'30"			
5	Хөвсгэлийн хорих айни	Хөвсгэл Мөрөн сум	49°33'00"	100°11'46"			
			49°33'00"	100°01'32"			
			49°32'31"	100°01'32"			
			49°32'31"	100°00'46"			
		Бүрэлдэхүүн орд	47°37'40"	100°15'00"	M-48-11	277	10
			47°37'40"	100°16'20"			
			47°37'00"	100°16'22"			
			47°37'00"	100°15'00"			
6	Хархоринь хорих айни	Өвөрхангай аймаг	47°04'52"	102°43'30"			
			47°04'52"	102°45'10"	L-48-26	380	5
			47°02'50"	102°45'10"			
			47°02'50"	102°43'30"			

ОРОН НУТГИЙН ХОРИХ АЙНИ

1	Сүхбаатар аймаг	Баруун -урт сум		L-49-47	50	5
2	Дорнод аймаг	Харзан сум		M-50-133	50	5
3	Булган аймаг	Булган сум		M-18-122	50	5
4	Говь-алтай аймаг	Алтай сум		L-47-49	50	5
5	Дархан-уул аймаг	Дархан сум		M-48-92	25	2
6	Архангай аймаг	Цэрэргээ сум		L-47-23	25	5
7	Баян-намийн аймаг	Өлгий сум		M-46-109	50	5
8	Завхан аймаг	Улаантаатай сум		L-47-23	25	5
9	Үсэг аймаг	Улаангом сум		M-46-77	25	5
10	Баянхонгор аймаг	Баянхонгор сум		L-47-70	25	5
11	Хөвд аймаг	Хөвд сум		M-46-136	25	5
12	Төв аймаг	Мянганомырт сум		M-49-145	25	5
13	Хэнтий аймаг	Өндөрхан сум		L-49-18	50	5
14	Өвөрхангай аймаг	Хархорин сум		L-47-23	50	5
15	Салэнгэ аймаг	Мандал сум		M-48-118	25	5
16	Салэнгэ аймаг	Мандал сум		M-48-118	25	5
17	Говьсүмбэр аймаг	Чойр сум		M-49-49	25	5
18	Орхон аймаг	Баян-онцөр сум		M-48-101	25	2
19	Баянзүрхийн хорих айни	Улаанбаатар Баянзүрх дүүрэг			250	20
20	Таширын ам дахь хорих айни	Улаанбаатар Сонинхайрхан дүүрэг			170	5

ТӨВЛӨРСӨН ХОРИХ АНГИУДЫН БАЙРШИЛ,
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛ

№	Хорих ангийн нэр	Байршил	Үйлдвэрлэлийн чиглэл
1	Авдрантын хорих анги	Төв аймгийн Лүн сум	Хөрс хуулалт Чулуу опборлолт, боловсруулалт
2	Баянзүрхийн хорих анги	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг	Оёдлын үйлдвэрлэл
3	Багануурын хорих анги	Багануур дүүрэг	Тоосгоны үйлдвэрлэл
4	Зүүнхараагийн хорих анги	Сэлэнгэ аймаг	Мод бэлтгэх болон боловсруулах үйлдвэрлэл Газар тариалан
5	Дарьтын хорих анги	Сэлэнгэ аймаг мандал сум	Мод бэлтгэх болон боловсруулах үйлдвэрлэл Газар тариалан
6	Хөвсгөлийн хорих анги	Хөвсгөл аймаг	Хөрс хуулалт Нүүрс опборлолт
7	Чойрын хорих анги	Говьсүмбэр аймаг Чойр хот	Эсгий, эсгий гутлын үйлдвэрлэл Ясны үйлдвэр
8	Мааньтын хорих анги	Төв аймгийн Баян сум	Хөрс хуулалт Шохойн чулуу опборлолт Шохой үйлдвэрлэлт Нүүрс опборлолт Тоосгоны үйлдвэрлэл
9	Барилгын материалын үйлдвэрлэлийн ашиглалтын өмнөх захиргаа	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг	Тоосгоны үйлдвэрлэл
10	Хархорины хорих анги	Өвөрхангай аймаг Хархорин сум	Аялал жуулчлал Мод бэлтгэл
11	Мөнгөнморьтын хорих анги	Төв аймгийн Мөнгөнморьт сум	Мод бэлтгэх болон боловсруулах үйлдвэрлэл Мод үргүүлэг
12	Амгалангийн хорих анги	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг	Барилгын материалын үйлдвэрлэл Барилгын сантехникийн ажил



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 7 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 114

Улаанбаатар
 хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын нийгэм, здийн засгийг хөгжүүлэх
2000 оны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ноолуур" хөтөлбөрийг 1 дүгээр
хавсралтын ёсоор, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг
улсын хэмжээнд эхийн байгуулах үүрэг бүхий
зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтын
ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл
ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн
улсын төсөөт тусган санхүүжүүлж байхын Сангийн
сайд Я.Очирсүх. Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд
Ч.Содномцэрэн нарт даалгасугай.

3.Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх

төслийнг сонирхогч орон, олон улсын
байгууллагад санал болгохыг Гадаад харилцаны
сайд Н.Туяад үүрэг болгосугай.

4.Хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн I
улиралд багтаан Засгийн газарт тайлагнах байхыг
Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөлийн дарга бөгөөд
Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэнд
даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий
сайд

Р.АМАРЖАРГАЛ

Хөдөө аж ахуй,
үйлдвэрийн сайд

Ч.СОДНОМЦЭРЭН

Засгийн газрын 2000 оны 114 дүтээр —
тогтоолын I дүтээр хавсралт

"НООЛУУР" ХӨТӨЛБӨР

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Ноолуур боловсруулах салбарын өвөөгийн
байдал

1990 оноос хойш ямаан сургийн тоо 2.1
дахин ёсч, нийт малын 32.9 хувийг зээлж байна.
Ямаан сургийн 29.3 хувийг ишиг, борлон, 25.8
хувийг бэлтгэлийн насын эр ямаа, 44.2 хувийг
хээлтэгч, 0.7 хувийг хээлтуулэгч зээлж байна.
1990 онд нийт ямааны 47.3 хувь нь хээлтэгч
байсан бол 1999 онд 44.2 хувь болжээ. Сургийн
бүтцэд өөрчлөлт орж, эр ямааны хувийн жин
өслөв.

Монгол улсын ноосон түүхий эдийн 7.8
хувийг ямааны ноолуур зээлж байна. 1999 оны
байдлаар ноолуур бэлтгэлийн нөөц 3450 тоннд
хүрлээ. Түүхий эдийн 80-ас дээш хувь нь 16.5
микроноос нарийн ноолуур байна.

Ноолуур боловсруулах салбарт
дотоодын 5 үйлдвэр, гадаадын хөрөнгө
оруулалттай хамтарсан 48 үйлдвэр ажиллаж
байна. Гадаадын хөрөнгө оруулалттай 48
үйлдвэрийн 4 нь сүлжмэлийн үйлдвэр байна.
1999 оны байдлаар жилдээ 5720 тонн ноолуур
угаах, 3250 тонн самнахи, 330 тонн утас зэрэх,
675 мянган ширхэг сүлжмэл эдлэл үйлдвэрлэх

хүчин чадал суурилагдаад байна. Ноолуур угаах,
самнахи хүчин чадал түүхий эдийн нэецээс 50
гаруй хувиар давжээ. Харин түүхий эдийн
нэецийн 20 гаруй хувийг ашиглан зэрмэл,
сүлжмэл үйлдвэрлэх хүчин чадал суурилагдсан
байна. Дийлэнх үйлдвэр, аж ахуйн газруудын
техник, технологийн түвшин тэр бүр олон улсын
стандартын шаардлагад нийцэхгүй,
хөдөлмөрийн нехцел доогуур байна.

2. Ноолууран бүтээгдэхүүний
өрсөлдөх чадвар

Дэлхийн зах зээлд ноолууран
эдлэлийн хэрэгцээ өслөө. АНУ, Европ, Азийн
орнууд жилд ойролцоогоор 2-6 сая ширхэг
сүлжмэл цамц импортолж байна. Дэлхийн зах
зээл дахь ноолууран бүтээгдэхүүний экспортын
зонхилох хувийг БНХАУ, Монгол, Итали улс
зээлж байна.

1999 онд манай улсын ноолууран
бүтээгдэхүүн, түүний дотор сүлжмэл эдлэлийн
үйлдвэрлэл 1995 оныхтой харьцуулахад 15.5
хувиар буурч, самнасан ноолуурын 9.5 хувиар
өсчээ. Манай улсын ноолууран эдлэлийн чанар
олон улсын стандартын түвшинд хүрч 1999 онд
Канад, Швейцар, ХБНГУ, АНУ, Итали зэрэг 15



оронд 314 мянган ширхэг сүлжмэл эдлэл экспортолсон боловч бүтээгдэхүүний нэр төрөл цөөн, хийц загвар зах зээлийн хэрэглээний өврчлэл шинчлэлтээс хоцорж байна. Самнасан ноолуурын үнэ дэлхийн зах зээлийн үнээс шуд хамаарч байгаа нь эдийн засгийн тогтвортой байдлыг бий болгож чадахгүй байна.

3.Хөтөлбөр боловсруулах ундэслэл

Монгол улсын нийтэм, эдийн засгийг хөгжүүлэх 2000 оны үндсэн чиглэлд «Ноолуур» хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхээр тусгагдсаныг үндэслэл болгов.

Хоёр.Хөтөлбөрийн зорилго,зорилт

4.Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь Монгол улсын ноолууран бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино.

5.Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр зорилт. Ямааны үүлдэр угсаа, ноолуурын чанарыг сайжруулах;

Хоёрдугаар зорилт. Ээрх, сүлжих, нэхэх хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар түүхий эдийг дотооддоо боловсруулж эсийн бүтээгдэхүүний үйлдвэрэлийг өргөжүүлэх;

Гуравдугаар зорилт. Бүтээгдэхүүний чанар, загвар чийцийг сайжруулан нэр төрлийг олшруулж, экспортыг нэмэгдүүлэх;

Гурав.Хэрэгжүүлэх арга хэмжээ

6.Нэгдүгээр зорилтын хүрээнд:

а/ямаан сүргийн тооллого явуулж, монгол үүлдрийн ямааны омог хэвшлийн тоо, хувийн жин, сүргийн бүтэц, тархалтын хүрээ, ямааны үүлдэрлэг байдлыг сум бүрээр тодорхойлох;

б/уржлийн шилмэл ямааны цөм сүргийг бүрдүүлж бүртгэлжүүлэх, бус нутгийг тогтоох, мэдээллийн сүлжээ бий болгох;

в/цем сүргийг түшиглэж стандартын шаардлага хангасан үржлийн хээлтэгч, хээлтүүлэгчийг бойжуулах иргэн, хуулийн этгээдийг санхүү, зээлийн бодлогоор

дэмжих;

г/«Говь гурван сайхан», «Уулын бор» ямааны селекцийн бодлогыг тодорхойлж, тэдээрийн цөм сүргийг сайжруулах арга хэмжээ авах;

д/туухий эд бэлтгэлийн системийг боловсронгуй болгох эрх зүйн үндсийг бүрдүүлэх.

7.Хоёрдугаар зорилтын хүрээнд:

а/эсийн бүтээгдэхүүний үйлдвэрэлийг дэмжих зээлийн бодлогыг хэрэгжүүлэх;

б/үйлдвэрэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, химиин болон бусад туслах материалыг импортлох уйл ажиллагааг эдийн засгийн аргаар дэмжих;

в/ээрмэл, нэмэмэл, сүлжмэлийн иж бүрдэл үйлдвэрэлэл эрхэлж буй аж ахуйн нэгжид эдийн засгийн хөнгөвлөлт үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, холбогдох хууль тогтооомжид нэмэлт, өврчлөлт оруулах;

г/эх орны ноолуурын үйлдвэрүүдийн хүчин чадлыг сэргээх, ашиглах, нэмэгдүүлэх үйл ажиллагааны тухайн үеийн байдалд нийцүүлж түүхий ноолуурын экспортыг уян хатан байдлаар зохицуулах, шаардлагатай үед тарифын бус хягаарлалт хийх асуудлыг судалж шийдвэрлэх.

8.Гуравдугаар зорилтын хүрээнд:

а/бүтээгдэхүүний чанар, хийц загварыг сайжруулахын тулд дараах чиглэлийн судалгаа хийж, үндэсний стандарт боловсруулан хэрэгжүүлэх;

-Ноолуур боловсруулах үйлдвэрийн техник, технологийн түвшинг үнэлэх;

-Ноолууран эзрэмэлийн техникийн нэхцэл;

-Ноолууран сүлжмэл эдлэлийн техникийн нэхцэл;

-Ноолууран нэмэмэл эдлэлийн техникийн нэхцэл;

-Ноолууран эдлэлийн гүйцэтгэн боловсруулалтын техникийн нэхцэл;

-Сэв хялгас боловсруулах техникийн нэхцэл;

-Ажлын байрны эрүүл ахуй,

хөдөлмерийн нэхцэлийн техникийн шаардлага;



-Хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны техникийн шаардлага.

б/ноолуурын бүтэц, шинж чанарын нэгдсан судалгаа явуулж, олон улсын мэдээлэл, стандартын албан ёсны бүртгэлд хамруулж, сурталчлах, чанарын тэмдэгтэй болгох;

в/эрдэм шинжилгээний байгууллагын техник, тоног төхөөрөмжийг шинчлэх;

г/онишилдэг загвар, бүтээгдэхүүн, загвар зохион бүтээгч, ўйлдвэрлэгч шалгаруулж урамшуулах;

д/олон улсын байгууллагын үзүүлж буй худалдааны хөнгөлөлтийгөөржүүлэх.

Дөрөв.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, хугацаа

9. Удирдлага, зохион байгуулалт

а/хөтөлбөрийг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих уургийг "Ноолуур" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөл гүйцэтгэнэ. Хөтөлбөрийн зөвлөлийг Хөдөө аж ахуйд, ўйлдвэрийн сайдв хадална. Зөвлөлийн дэргэд орон тооны нэг ажилтан ажиллана. Орон тооны ажилтан ажиллуулах зардлыг Хөдөө аж ахуйд, ўйлдвэрийн яамны төсөөт тусгаж санхүүжүүлнэ;

б/Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

-Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах;

-Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар жил бүр хийх ажлын төлөвлөгөө боловсруулах, зардлын төсвийн тооцоо хийж, санхүүжүүлэх эх үүсвэрэйг тогтоох, холбогдох зардлыг улсын төсөөт тусгуулах арга хэмжээ авах;

-Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх;

-Хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газарт тайлагнах;

-Зөвлөлийн ўйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Зөвлөл улиралд нэгээс доошгүй хуралдаа бөгөөд шаардлагатай

үед зөвлөлийн дарга хуралдааныг зарлан хуралдуулж болно.

в/Зөвлөлийн ўйл ажиллагааг дүрмээр зохицуулна. Дүрмийг зөвлөлийн дарга батална.

10. Санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахъ санхүүгийн эх үүсвэрэйг ашиглана:

а/улсын төсөв; б/олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламж; в/гадаадын хөрөнгө оруулалт; г/уйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө; д/бусад.

11. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2001-2006 онд дараахъ ўе шаттайгаар хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр ўе шат. 2001-2002 он. Ноолуурын үндэсний стратегийг тодотгон боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх эрх зүй, зохион байгуулалтын үндсийг бурдүүлэх;

Хоёрдугаар ўе шат. 2002-2004 он. Ноолуур боловсруулах арга, технологийг олон улсын стандарт, техникийн шаардлагад бүрэн нийцүүлэх;

Гуравдугаар ўе шат. 2004-2006 он. Монгол улсын ноолууран бүтээгдэхүүний дэлхийн зах эзэлд тогтвортой өрсөлдөх чадвартай болгох.

Тав.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах ўр дүн

12. Гарах ўр дүн

а/түүхий эдийн экспорт багасаж, түүнийг дотооддо боловсруулах хүчин чадал нэмэгдэж бүтээгдэхүүний ўйлдвэрлэл ёсне;

б/ноолууран бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж, ўйлдвэр, аж ахуйн нэгжийн эдийн засгийн чадавхи сайжирна;

в/ноолууран бүтээгдэхүүний нэр төрөл олширч, загвар хийц дээшилнэ;

г/дэлхийн зах эзэлд өрсөлдөх чанартай бүтээгдэхүүний тоо нэмэгдэнэ.

Засгийн газрын 2000 оны 114 дугаар
тогтоолын 2 дутаар хавсралт

**“НООЛУУР” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДХҮҮН**

Дарга	Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд	агентлагын дарга
Гишүүд:	Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга; Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Стратегийн төлөвлөлт, нэгдсэн бодлогын газрын Үйлдвэр, худалдааны албаны дарга;	Техникийн их сургуулийн Нэхмэлийн хүрээлэнгийн захирал;
	Хөдөө аж ахуйн газрын дарга;	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал;
	Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн дарга;	Монголын Ноос, ноолуурын холбооны тэргүүн / тохиролцсоноор/;
	Гадаадын хөренгэ оруулалт, гадаад худалдааны	Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны ерөнхийлөгч /тохиролцсоноор/.
		Нарийн бичгийн дарга
		Хөтөлбөрийн орон тооны ажилтан

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 7 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 116

Улаанбаатар
хот

**Шүүхийн байгууллагын талаараавах
зарим арга хэмжээний тухай**

Шүүхийн байгууллагын үйл ажиллагааны хувийн нехцэлийг хангаж, шүүгчийн хараат бус байдлыг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэхэд замжлаг үзүүлэх зорилгоор «Шүүхийн замжлагсан»-г байгуулж, эх үүсвэрт нь гадаадын хандивлагын хандив туслах, терийн вчийн банины хугацаа хэтэрслэн зээлийн ерийг барагдуулах хүрээнд хуримтлуулсан хөрөнгөөс бүрдүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүйн сайд Д.Ганболд, Сангиин сайд Я.Очирсүх, Гадаад харицааны сайд Н.Туяа нарт даалгасугай.

2.Говьсүмбэр, Төв, Ховд, Баян-Өлгий аймагийн шүүхийг албан көнтортой болгох, Орхон аймаг, Нийслэлийн Налайх дүүргийн шүүхийн байрны өмчийн харьвалыг шийдвэрэлж шүүхийн мэдрэл шилжүүлэх асуудлыг шийдвэрэлж арга хэмжээ авахыг Төрийн эмчийн хорооны дарга Д.Зоригтод даалгасугай.

3.Шүүхүүдээд 1993 оноос хойш хуримтлагдсан 125.5 сая төгрөгийн ургаслазарлын ерийг энэ оны Шалиралд барагдуулах арга хэмжээ авахыг Хууль зүйн сайд Д.Ганболд, Сангиин сайд Я.Очирсүх нарт үүргэ болгосугай.

4.Шүүхийн байгууллагудын автомашины паркыг шинчлах, шүүгч нарын орон сууцаар хангах асуудлыг шийдвэрэлж хөрөнгийн эх үүсвэрт 2001 оноос эхлэн дас дараатайгаар шийдвэрэлж арга хэмжээ авахыг Сангиин сайд Я.Очирсүх, Хууль зүйн сайд Д.Ганболд нарт даалгасугай.

5.Шүүхийн байгууллагын ажлын ачааллыг харгалзан Нийслэлээ, дүүргүүдийн шүүхэд туслах шүүгч, нарийн бичгийн даргын орон тоог 12-сөр, Сэлэнгэ аймгийн Зүүнхаараа, Дорноговь аймгийн Замын-үүдийн шүүх шинэ байранд орсондой холбогдуулан орон тоог 18-аар тус тус нэмэгдүүлж тэдээрэйн цалингийн санд шаардлагдах 13434.6 мянган төгрөг; Улсын дээд шүүх, Төв аймаг, Булган аймгийн шүүх, Завхан аймгийн Булнаа, Хэнтий аймгийн Бор-эндер, Дорноговь аймгийн Замын-үүд, Сэлэнгэ аймгийн Зүүнхаараагийн сум дундын шүүх, Нийслэлийн шүүхийн барилын засварт шаардлагдах 33,0 сая төгрөгийн зардлыг 2000 оны шүүхийн төсвийн тодотой болон 2001 оны төвлөрөн төсвөт тусгахыг Сангиин сайд Я.Очирсүхэд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Р.АМАРЖАРГАЛ

Хууль зүйн сайд

Д.ГАНБОЛД

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

№ 329612
Индекс 14003

№ 329487